



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэврэй сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ӨМА-2024/43/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.Umnugovi@audit.mn
Өмнөговь аймаг
Даланзадгад сум
2024 он

Өмнөговь дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор:
Ц.Өсөхбаяр
Утас: 70533539 Цахим хаяг: Usukhbayarts@audit.gov.mn
Аудитын менежер: Т.Хонгорзул
Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn
Ахлах аудитор: С.Одончимэг
Утас: 70533552 Цахим хаяг: Odonchimegs@audit.gov.mn
Аудитор: Э.Жаргал
Утас: 70533552 Цахим хаяг: jargale@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnogovi@audit.gov.mn

2024.02.22 № 78
танай _____-ны № _____-т

СЭВРЭЙ СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Д.ГАНТУЯА ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэврэй сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Сэврэй сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төсвийн шууд захирагчийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан, бараа материалын тооллого хийгээгүй, төсвийн зарлагын эдийн засгийн ангилал зөрүүтэй бүртгэсэн 9,291.9 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс өндөр бөгөөд Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-тай нийцээгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байх, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус байгууллага нь аймгийн тэргүүний иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын байгууллагаар шалгарч 3,000.0 мянган төгрөгийн мөнгөн шагналаар шагнагдан албан хаагчдадаа олгосон байна.

Аудитын гол асуудал

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар иргэний танхимын тохижилтод зориулсан 18,814.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсан байна.

016020179

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 65 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг 92.3 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	3,292,850.00	3,592,343.19
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
3121	Төгрөг	-	-
31211	Төрийн сангийн харилцах	-	-
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	-	-
33	АВЛАГА	-	597,443.19
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	597,443.19
35	БАРАА МАТЕРИАЛ	3,292,850.00	2,994,900.00
354	Хангамжийн материал	3,292,850.00	2,994,900.00
35410	Бичиг хэргийн материал	1,755,850.00	1,547,900.00
35420	Аж ахуйн материал	37,000.00	37,000.00
35470	Бусад хангамжийн материал	1,500,000.00	1,410,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	37,988,715.97	51,611,984.02
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	37,988,715.97	51,611,984.02
392	Биет хөрөнгө	37,988,715.97	51,611,984.02
39203	Авто-тээврийн хэрэгсэл	28,742,467.00	28,742,467.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(9,580,822.32)	(19,161,644.64)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	19,763,600.00	38,684,100.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(8,820,475.86)	(6,408,275.10)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	8,839,643.59	12,686,210.21
39208	Хуримтлагдсан элэгдэл	(2,053,679.82)	(3,904,556.87)
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,243,000.00	1,243,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(145,016.62)	(269,316.58)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	41,281,565.97	55,204,327.21
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	41,281,565.97	55,204,327.21
51	Засгийн газрын хувь оролцоо	41,281,565.97	55,204,327.21
511	Засгийн газрын оруулсан капитал /орон нутгийн сан/	16,130,186.00	16,130,186.00
51101	Өмч: - төрийн	16,130,186.00	16,130,186.00
512	Хуримтлагдсан үр дүн	25,151,379.97	39,074,141.21
51210	Өмнөх үеийн үр дүн	25,151,379.97	25,151,379.97
51220	Тайлант үеийн үр дүн	-	13,922,761.24
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	41,281,565.97	55,204,327.21

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	100,899,268.00	185,835,505.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,744,800.00	3,465,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	3,744,800.00	3,465,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,744,800.00	3,465,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	3,744,800.00	3,465,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	97,154,468.00	182,370,505.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,345,968.00	13,761,905.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	645,968.00	13,761,905.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,700,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	93,808,500.00	168,608,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	93,808,500.00	168,608,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	113,225,953.70	190,674,393.75
21	УРСГАЛ ЗАРДАЛ	113,225,953.70	190,674,393.75
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	100,460,496.81	133,210,805.22

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	45,181,420.00	68,919,546.93
210101	Үндсэн цалин	28,940,821.00	35,822,289.49
210102	Нэмэгдэл	9,900,659.00	28,797,996.24
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,101,000.00	3,101,000.00
210104	Урамшуулал	3,238,940.00	1,198,261.20
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,362,766.11	8,568,351.35
210201	Тэтгэврийн даатгал	3,651,489.08	5,690,939.48
210202	Тэтгэмжийн даатгал	427,824.51	642,006.64
210203	ҮОМШӨ-ний даатгал	342,252.60	643,598.22
210204	Ажилгүйдлийн даатгал	85,567.90	132,607.93
210205	Эрүүл мэндийн даатгал	855,632.02	1,459,199.08
2104	Хангамж, бараа материалын зардал	6,807,200.00	8,080,750.00
210401	Бичиг хэрэг	2,729,550.00	2,486,950.00
210402	Тээвэр, шатахуун	3,491,950.00	5,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	100,000.00	3,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	485,700.00	90,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	500,000.00	500,000.00
210604	Урсгал засвар	500,000.00	500,000.00
2107	Томилолт, зочны зардал	460,000.00	1,929,700.00
210702	Дотоод албан томилолт	460,000.00	1,929,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,294,875.00	15,975,125.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	20,294,875.00	15,975,125.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	21,854,235.70	29,237,331.94
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,180,000.00	1,926,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,141,000.00	10,707,950.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодол	16,533,235.70	16,603,381.94
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,765,456.89	57,463,588.53
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,745,968.00	15,603,905.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,745,968.00	15,603,905.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	11,019,488.89	41,859,683.53
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,019,488.89	41,859,683.53
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(12,326,685.70)	(4,838,888.75)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	495,000.00	52,750.01
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	495,000.00	52,750.01
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(495,000.00)	(52,750.01)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(12,821,685.70)	(4,891,638.76)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	97,154,468.00	182,370,505.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	97,154,468.00	182,370,505.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,345,968.00	13,761,905.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагадаггүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	645,968.00	13,761,905.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,700,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	93,808,500.00	168,608,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	93,808,500.00	168,608,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	97,154,468.00	174,370,505.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	97,154,468.00	174,370,505.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	84,289,011.11	116,906,916.47
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	45,181,420.00	69,356,433.42
210101	Үндсэн цалин	28,940,821.00	34,347,965.60
210102	Нэмэгдэл	9,900,659.00	29,384,925.82
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,101,000.00	3,101,000.00
210104	Урамшуулал	3,238,940.00	2,522,542.00

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,362,766.11	8,728,908.05
210201	Тэтгэврийн даатгал	3,651,489.08	5,935,862.82
210202	Тэтгэмжийн даатгал	427,824.51	557,640.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	342,252.60	705,672.00
210204	Ажилгүйдлийн даатгал	85,567.90	134,853.23
210205	Эрүүл мэндийн даатгал	855,632.02	1,394,880.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,985,200.00	6,680,800.00
210401	Бичиг хэрэг	548,000.00	1,177,000.00
210402	Тээвэр, шатахуун	3,337,200.00	5,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	100,000.00	3,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	500,000.00	500,000.00
210604	Урсгал засвар	500,000.00	500,000.00
2107	Томилолт, зочны зардал	460,000.00	1,929,700.00
210702	Дотоод албан томилолт	460,000.00	1,929,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,659,625.00	16,266,125.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	21,659,625.00	16,266,125.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,140,000.00	13,444,950.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,300,000.00	1,926,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,840,000.00	11,518,950.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,865,456.89	57,463,588.53
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,845,968.00	15,603,905.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,845,968.00	15,603,905.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	11,019,488.89	41,859,683.53
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,019,488.89	41,859,683.53
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	=	8,000,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	8,000,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	8,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	8,000,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	8,000,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	=	(8,000,000.00)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	-	-
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	16,130,186.00	-	25,151,379.97	41,281,565.97
2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	16,130,186.00	-	25,151,379.97	41,281,565.97
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	16,130,186.00	-	25,151,379.97	41,281,565.97
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	13,922,761.24	13,922,761.24
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	16,130,186.00	-	39,074,141.21	55,204,327.21

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Тайлант оны гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		
21	УРСГАЛ ЗАРДАЛ	168,608,600.00	118,748,916.47
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	168,608,600.00	118,748,916.47
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	124,708,600.00	113,056,916.47
210101	Үндсэн цалин	71,937,500.00	69,356,433.42
210102	Нэмэгдэл	34,500,000.00	34,347,965.60
210103	Унаа хоолны хөнгөлөлт	29,837,500.00	29,384,925.82
210104	Урамшуулал	3,200,000.00	3,101,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,400,000.00	2,522,542.00
210201	Тэтгэврийн даатгал	9,012,500.00	8,728,908.05
210202	Тэтгэмжийн даатгал	6,128,500.00	5,935,862.82
210203	ҮОМШӨ-ний даатгал	576,800.00	557,640.00
210204	ҮОМШӨ-ний даатгал	721,000.00	705,672.00
210205	Ажилгүйдлийн даатгал	144,200.00	134,853.23
210205	Эрүүл мэндийн даатгал	1,442,000.00	1,394,880.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,442,000.00	1,394,880.00
210401	Бичиг хэрэг	7,100,000.00	6,680,800.00
210402	Тээвэр, шатахуун	1,570,000.00	1,177,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,500,000.00	5,500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	30,000.00	3,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	8,500,000.00	500,000.00
210604	Урсгал засвар	8,000,000.00	-
2107	Томилолт, зочны зардал	500,000.00	500,000.00
210702	Дотоод албан томилолт	2,000,000.00	1,929,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,000,000.00	1,929,700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,600,000.00	12,416,125.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,600,000.00	12,416,125.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,558,600.00	13,444,950.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,000,000.00	1,926,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,558,600.00	11,518,950.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	43,900,000.00	5,692,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	43,900,000.00	5,692,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	37,900,000.00	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	6,000,000.00	5,692,000.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	168,608,600.00	210,468,283.53
132001	Орон нутгийн төсвөөс	168,608,600.00	210,468,283.53
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Тайлант оны гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	13,761,905.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	13,761,905.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,850,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,850,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,850,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,911,905.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,911,905.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,911,905.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	13,761,905.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	13,761,905.00

131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,761,905.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 44,485.5 мянган төгрөгийн алдаа илэрсэн нь УСНББОУС-1 санхүүгийн тайлангийн толилуулга, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул залруулав. Үүнд:

- Мөнгөн гүйлгээний тайлангийн биет ба биет бус хөрөнгө худалдан авах зардлыг үндсэн хөрөнгийн тодруулга тайлан дахь худалдан авсан хөрөнгийн дүнтэй тулган баталгаажуулахад 8,000.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан
- Санхүүгийн үр дүнгийн тайлангийн цалингийн зардлын дүнг цалингийн баталгаажсан цэстэй тулган баталгаажуулахад 436.8 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан
- Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг зардлыг санхүүжүүлэх эх үүсвэртэй тулган баталгаажуулахад 15,665.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан
- Өглөгийн тодруулга тайлангийн ХХОАТ-ын дүнг цалингийн баталгаажсан цэсийн ХХОАТ-ын суутгалын дүнтэй тулган баталгаажуулахад 5,771.7 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан
- Өглөгийн тодруулга тайлангийн нийгмийн даатгалын шимтгэлийн дүнг мөнгөн гүйлгээний тайлангийн дүнтэй тулган уг зардалтай тулган баталгаажуулахад 7,778.4 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан
- Тайлант хугацаанд 3,938.0 мянган төгрөгийн урьдчилгаа цалин олгохдоо өглөгөөр хүлээн зөвшөөрч тайлагнасан
- Мөнгөн гүйлгээний тайлангийн хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлын дүнг санхүүгийн үр тайлангийн уг зардалтай тулган баталгаажуулахад 2,298.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан
- Тайлант онд 597.4 мянган төгрөгийн ХХОАТ-ын авлагыг бүртгэлд тусгаагүй тайлагнасан

Аудитаар нийт 8,394.5 мянган төгрөгийн 6 зөрчил илэрсэнд хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллах, зөвлөмж өгч ажиллалаа. Үүнээс хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн акт, албан шаардлага байхгүй.

3.1 Төлбөрийн акт

Илрүүлэлт-1: Тайлант хугацаанд 2 албан хаагчид хоолны хөнгөлөлт олгохдоо албан томилолтоор ажилласан хугацааг хасаж тооцоогүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх", Сангийн сайдын 1992 оны 39 дугаар тушаалаар баталсан "Албан томилолтын зардал олгох заавар"-ын 5 "Ажилчин, албан хаагчид албан томилолтоор ажилласан хугацаандаа албан тушаалын буюу тарифт цалингаа өөрийн байгууллагаасаа авна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУ-ын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.5 "бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн" заасны дагуу төлбөрийн акт тогтоох

Илрүүлэлт-2: 1 албан хаагчид 500,0 мянган төгрөгийн түлээ нүүрсний хөнгөлөлт олгохдоо төвийн дулаанд холбогдсон айл өрхөд олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Засгийн газрын 2021 оны 6 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчид нөхөн төлбөр олгох журам"-ын 8 дугаар зүйлийн 8.3 "Ердийн галлагаатай сууцанд амьдардаг төрийн албан хаагчид өвлийн улирлын түлш худалдан авах зардлын зохих хэсгийг байгууллагаас нөхөн олгож болно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУ-ын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.3 "цалин хөлс, шагнал урамшуулал тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" заасны дагуу төлбөрийн акт тогтоох

Илрүүлэлт-3: Тайлант хугацаанд нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлаас ИТХ-ын хурлын даргад 300.0 мянган төгрөгийн тэтгэмж олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 "Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно", 12.1.4 "хуулиар зөвшөөрөөгүй бусад" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2022 оны 11 сарын 25-ны өдрийн А/89 дугаар тушаалаар баталсан "Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого чиглэлийг хэрэгжүүлэх заавар"-ын 1 дүгээр хавсралтын 8.4-д заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоох

3.2 Албан шаардлага

Илрүүлэлт-1: Тайлант хугацаанд нягтлан бодогч нь 4,082,5 мянган төгрөгийн тээвэр шатахууны зарцуулалтын нормын тооцоо бодоогүй, жолоочийн тооцооны хуудсыг баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх", Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны "Жишиг норм батлах тухай" 390 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтад заасныг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шатахуун зарцуулалтын нормыг бодож, баталгаажуулан ажиллаж хэвших.

Илрүүлэлт-2: ИТХ-ын төлөөлөгч Б.Баяржаргалд 2,000,0 мянган төгрөгийн буцалтгүй тусламж олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Авлигын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 "Энэ хуулийн 4.1-д заасан этгээдэд бусад хууль тогтоомжид тусгайлан хориглоноос гадна авлигын дараах зөрчлийг хориглоно", 7.1.7 "албан тушаалын байдлаа ашиглан эд хөрөнгө олж авах, давуу эрх эдлэх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зориулалтын дагуу, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зарцуулан ажиллах.

Илрүүлэлт-3: Шилэн дансны мэдээллийг тулган баталгаажуулахад цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 138,092.8 мянган төгрөгийн 13 мэдээллийг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулаа, хүлээн авагчийн нэрээр мэдээлнэ" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Илрүүлэлт-4: Шилэн дансны нэгдсэн системд байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийн мэдээллийг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", 6.4.7 "байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт", 6.10 "Шилэн дансны мэдээлэл, зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хуулбар, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг хавсаргасан байна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй төсвийн шууд захирагчид Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 "Энэ хуулийн 16 дугаар зүйлд

заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно"-д заасныг үндэслэн сахилгын хариуцлага тооцуулах тухай албан шаардлага хүргүүлэх

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1.Дотоод хяналттай холбоотой асуудал

Илрүүлэлт-1: ИТХ-ын даргын 2023 оны 14/01 дугаар тогтоолоор баталсан хөдөлмөрийн дотоод журамд Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төсвийн тухай хуульд нийцээгүй заалтууд батлан хэрэгжүүлэн ажилласан байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 122 дугаар зүйлийн 122.1 "Ажил олгогч ажилтны төлөөлөгчийн саналыг харгалзан хууль тогтоомжид нийцүүлэн тухайн аж ахуйн нээж, байгууллагын хэмжээнд үйлчлэх хөдөлмөрийн дотоод журмыг баталж мөрдүүлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хөдөлмөрийн тухай хууль, бусад хуульд нийцүүлэн шинэчлэн баталж ажиллах.

Дээрх албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Мөнгөн гүйлгээний тайлангийн биет ба биет бус хөрөнгө худалдан авах зардлыг үндсэн хөрөнгийн тодруулга тайлан дахь худалдан авсан хөрөнгийн дүнтэй тулган баталгаажуулахад 8,000.0 төгрөгөөр дутуу тайлагнасан	1	8,000.00	-	-	1	8,000.00	1	8,000.00	-	-	-	-
Санхүүгийн үр дүнгийн тайлангийн цалингийн зардлын дүнг цалингийн баталгаажсан цэстэй тулган баталгаажуулахад 436.8 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан	1	436.89	-	-	1	436.89	1	436.89	-	-	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг зардлыг санхүүжүүлэх эх үүсвэртэй тулган баталгаажуулахад 15,665.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан	1	15,665.00	-	-	1	15,665.00	1	15,665.00	-	-	-	-
Өглөгийн тодруулга тайлангийн ХХОАТ-ын дүнг цалингийн баталгаажсан цэсийн ХХОАТ-ын суутгалын дүнтэй тулган баталгаажуулахад 5,771.7 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан	1	5,771.79			1	5,771.79	1	5,771.79				
Өглөгийн тодруулга тайлангийн нийгмийн даатгалын шимтгэлийн дүнг мөнгөн гүйлгээний тайлангийн дүнтэй тулган уг зардалтай тулган баталгаажуулахад 7,778.4 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан	1	7,778.41			1	7,778.41	1	7,778.41				
Тайлант хугацаанд 3,938.0 мянган төгрөгийн урьдчилгаа цалин олгохдоо өглөгөөр хүлээн зөвшөөрч тайлагнасан	1	3,938.00			1	3,938.00	1	3,938.00				
Мөнгөн гүйлгээний тайлангийн хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлын дүнг санхүүгийн үр тайлангийн уг зардалтай тулган баталгаажуулахад 2,298.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан	1	2,298.00			1	2,298.00	1	2,298.00				
Тайлант онд 597,443.19 төгрөгийн ХХОАТ-ын авлагыг бүртгэлд тусгаагүй тайлагнасан	1	597.44	-	-	1	597.44	1	597.44	-	-	-	-
Дүн	8	44,485.5	-	-	8	44,485.5	8	44,485.5	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант хугацаанд 2 албан хаагчид хоолны хөнгөлөлт олгохдоо албан томилолтоор ажилласан хугацааг хасаж тооцоогүй	1	112.00	1.0	112.0	-	-	-	-	-	-	-	-
Тайлант хугацаанд нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлаас ЗДТГ-ын нягтлан бодогч, нярав нарт 1,700.0 мянган төгрөгийн тэтгэмж олгосон байна	1	1,700.00	-	-	1.0	1,700.0	-	-	-	-	-	-
Тайлант хугацаанд 1 албан хаагчид 500.0 мянган төгрөгийн түлээ нүүрсний хөнгөлөлт олгохдоо төвийн дулаанд холбогдсон айл өрхөд олгосон байна.	1	500.00	1.0	500.0	-	-	-	-	-	-	-	-
Тайлант хугацаанд нягтлан бодогч нь 4,082.5 мянган төгрөгийн тээвэр шатахууны зарцуулалтын нормын тооцоо бодоогүй, жолоочийн тооцооны хуудсыг баталгаажуулаагүй байна.	1	4,082.55	-	-	1.0	4,082.6	-	-	-	-	-	-
Тайлант хугацаанд сумын ИТХ-ын төлөөлөгч Б.Баяржаргалд 2,000.0 мянган төгрөгийн буцалтгүй тусламж олгосон байна.	1	2,000.00	-	-	1.0	2,000.0	-	-	-	-	-	-
ИТХ-ын даргын 2023 оны 14/01 дугаар тогтоолоор баталсан хөдөлмөрийн дотоод журамд Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төсвийн тухай хуульд нийцээгүй заалтууд батлан хэрэгжүүлэн ажилласан байна.	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
Дүн	6	8,394.55	2	612.0	3	7,782.6	1	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны мэдээллийг тулган баталгаажуулахад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 138,092.8 мянган төгрөгийн 13 мэдээллийг байршуулаагүй	1	138,092.80	-	-	1	138,092.80	-	-
Шилэн дансны нэгдсэн системд байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийн мэдээллийг байршуулаагүй	1	-	-	-	-	-	-	-
Дүн	2	138,092.8	-	-	1	138,092.80	-	-
Бусад хууль, тогтоомжтой холбоотой зөрчил								
Тайлант хугацаанд нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлаас ИТХ-ын хурлын даргад 300.0 мянган төгрөгийн тэтгэмж олгосон	1	300.00	1	300.00	-	-	-	-
Дүн	1	300.00	1	300.00	-	-	-	-
Нийт дүн	3	138,392.8	1	300.00	1	138,092.80	-	-

/мянган төгрөгөөр/